



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

“Эрнст энд Янг монголия аудит” ХХК-ийг  
үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх  
аудитын компаниар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай” журмын 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрнст энд Янг монголия аудит” ХХК-ийг үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар 3 жилийн хугацаагаар бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эрнст энд Янг монголия аудит” ХХК / М.Уянга /-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000327